



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2025.01.07 № 01/47
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. *Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг хэрэгжүүлэх талаар:*

1.1. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу ажил олгогчийн болон даатгуулагчийн төлөх тэтгэврийн (8.5, 8.5), тэтгэмжийн (1.0, 0.8), ажилгүйдлийн (0.5, 0.2), үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний (0.5, 1.5, 2.5), эрүүл мэндийн (2.0, 2.0) даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдөөгүй тул хэвээр мөрдөнө.

1.2. “Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрөл, код”-ын жагсаалтыг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7, мөн хуулийн 21 дүгээр зүйлд заасныг баримтлан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн “Маягтын загвар, аргачлал батлах тухай” А/44, А/40 дүгээр хамтарсан тушаалаар баталсан болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Даатгуулагчийн төрлийн код нэмж батлах тухай” А/43 дугаар тушаалаар нэмж баталсан даатгуулагчийн төрлийн кодыг хэвээр мөрдөнө.

1.3. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 03 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс цагт 4715 төгрөг буюу сард 792 000 (долоон зуун ерөн хоёр мянга) төгрөг байхаар шинэчлэн тогтоосон.

Иймд 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдөхтэй холбоотойгоор дараах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана уу. Үүнд:

1.3.1. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь албан журмаар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна гэж заасны дагуу албан журмаар даатгуулагчийн шимтгэл төлөх сарын цалин хөлсний дээд хэмжээ 7 920 000 (792 000*10) төгрөг, сард төлөх шимтгэлийн дээд хэмжээ нь 910 800 (7 920 000*11.5%) төгрөг байна.

1525070051

1.3.2.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь сайн дураар даатгуулагчийн хувьд 7 дахин нэмэгдүүлсэнтэй тус тус тэнцүү байна” гэж заасны дагуу сайн дураар даатгуулагчийн сард төлөх шимтгэлийн доод хэмжээ нь 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд 89 100 төгрөг (660 000 төгрөг*13.5%), дээд хэмжээ 623 700 төгрөг (4 620 000 төгрөг*13.5%), 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард төлөх шимтгэлийн доод хэмжээ 106 920 төгрөг (792 000 төгрөг*13.5%), дээд хэмжээ 748 440 (5 544 000*13.5%) төгрөг байна.

1.3.3.Сайн дурын даатгалын гэрээнд “Гэрээний хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны шийдвэрээр шинэчлэн тогтоосон тохиолдолд уг шийдвэрийг хэрэгжих хугацаанаас нь эхлэн дагаж мөрдөнө” гэж заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (660 000)-нээс 791 999 төгрөгийн хоорондох орлогоос шимтгэл төлөхөөр байгуулсан гэрээний хугацаа нь 2025 он дамжин үргэлжилж байгаа тохиолдолд 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шимтгэл ногдуулан төлөх орлогын доод хэмжээг 792 000 төгрөгөөр шууд өөрчилнө.

Харин сайн дураар даатгуулагч 2024 онд шимтгэл төлөх орлогоо хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээгээр буюу 4 620 000 төгрөгөөр тодорхойлж байгуулсан сайн дурын даатгалын гэрээний хугацаа нь 2025 он дамжин үргэлжилж байгаа тохиолдолд 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шимтгэл төлөх орлогын хэмжээг даатгуулагчаас өөрөөс нь санал авч өөрчилнө.

1.3.4.Сайн дурын даатгалын гэрээний хугацаа 2025 он дамжин үргэлжилж байгаа тохиолдолд уг гэрээний хугацаанд гэрээний маягтыг солихгүй. Харин 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш шинээр байгуулсан болон өмнө байгуулсан гэрээний хугацаа дууссан тохиолдолд сайн дурын даатгалын гэрээг шинээр байгуулна.

1.3.5.Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан, хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа даатгуулагчийн төрлийн “64004” кодтой сайн дураар даатгуулагч эх, жирэмсний болон амаржсаны тэтгэмж аваагүй, хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа даатгуулагчийн төрлийн “65004” кодтой сайн дураар даатгуулагч эх шимтгэл төлөх орлогоо 2024 онд 792 000 төгрөгөөс бага хэмжээгээр тодорхойлж, сайн дурын даатгалын гэрээний хугацаа нь 2025 он дамжин үргэлжилж байгаа эсхүл шинээр гэрээ байгуулсан тохиолдолд 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шимтгэлийг 792 000 төгрөгөөс тооцон төлүүлнэ.

1.3.6.2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 792 000 төгрөгөөс төлбөл зохих шимтгэл 57420 төгрөг (тэтгэврийн даатгалын 5.75 хувь болох 45540 төгрөг, тэтгэмжийн даатгалын 0.5 хувь болох 3960 төгрөг, үйлдвэрлэлийн ослын даатгалын 1 хувь болох 7920 төгрөг)-ийг өөрөө хариуцан төлнө. Энэ тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (792 000 төгрөг)-нээс тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын 12.5 хувиар тооцсон дүн (99 000 төгрөг)-гийн 50 хувь буюу 49500 төгрөг (тэтгэврийн даатгалын 5.75 хувь болох 45 540 төгрөг, тэтгэмжийн даатгалын 0.5 хувь болох 3960 төгрөг)-ийг улсын төсвөөс эсхүл тэтгэмжийн даатгалын сангаас төлүүлнэ.

1.3.7.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш орлогоос шимтгэл төлж байгаа жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан, хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа даатгуулагчийн төрлийн “64014” кодтой сайн дураар даатгуулагч эх, жирэмсний болон амаржсаны тэтгэмж аваагүй, хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа даатгуулагчийн төрлийн “65014” кодтой сайн дураар даатгуулагч эхийн сайн дурын даатгалын гэрээний хугацаа нь 2025 он дамжин үргэлжилж байгаа эсхүл шинээр

байгуулсан тохиолдолд 2025 оны 04 дүгээр сарын 01-нээс эхлэн төлөх шимтгэлээс тэтгэмжийн сан болон улсын төсвөөс хариуцан төлөх 49500 төгрөг (тэтгэврийн 5.75 хувь 45540 төгрөг, тэтгэмжийн 0.5 хувь 3960 төгрөг)-ийг хасаж үлдэх тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн зөрүү, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг даатгуулагч өөрөө хариуцан төлнө.

Дээр дурдсан даатгуулагчийн төрлийн "64004", "65004", "64014", "65014" кодтой даатгуулагч эхийн сайн дурын даатгалын гэрээний хугацаа (хүүхдийг нь 3 нас хүртэл)-ны дотор гэрээ байгуулснаас хойш 12 сар тутамд нэг удаа шимтгэл төлөх цалин хөлсний хэмжээгээ өөрчлөх боломжтой.

Даатгуулагч эх гэрээний хугацаанд дахин хүүхэд төрүүлбэл шинээр төрсөн хүүхдийн мэдээллээр гэрээг шинэчлэн байгуулна. Энэ тохиолдолд өмнөх гэрээг шинэчлэх хүсэлт гаргах хүртэлх хугацааны шимтгэлийг даатгуулагч бүрэн төлсөн байх шаардлагатай.

1.3.8.Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй даатгуулагчийн төрлийн "78004", "78014" кодтой эх /эцэг/-ийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс шимтгэл төлөх бол даатгуулагчийн регистрийн болон иргэний бүртгэлийн дугаараар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын мэдээллийн сантай тулган шалгаж, гэрээ байгуулна.

Даатгуулагчийн төрлийн "78004" кодтой даатгуулагч эх /эцэг/-ийн тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэл 15840 төгрөг (тэтгэмжийн даатгалын 1 хувь болох 7920 төгрөг, үйлдвэрлэлийн ослын даатгалын 1 хувь болох 7920)-ийг даатгуулагч өөрөө хариуцан төлнө. Харин хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (792 000 төгрөг)-нээс тэтгэврийн даатгалын шимтгэлийн 11.5 хувиар тооцсон дүн буюу 91080 төгрөгийг улсын төсвөөс төлүүлнэ.

Байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй даатгуулагчийн төрлийн "78014" кодтой даатгуулагч эх /эцэг/ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш орлогоос шимтгэл төлөх бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (792 000 төгрөг)-нээс тэтгэврийн даатгалын шимтгэлийн 11.5 хувиар тооцсон дүн буюу 91080 төгрөгийг улсын төсвөөс, үлдэх тэтгэврийн даатгалын шимтгэлийн зөрүү, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг даатгуулагч өөрөө бүрэн хариуцан төлөх бөгөөд гэрээний хугацаа нь 12 сараас дээш байх тохиолдолд 12 сар тутамд нэг удаа цалин хөлсний хэмжээг өөрчилж болно.

1.3.9.Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаагаас бусад малчин, туслах малчин даатгуулагчийн гэрээний хугацаа нь 1-12 сар байна. Сайн дураар даатгуулагч малчны шимтгэлийг улсын төсвөөс хариуцан төлөх нийт хугацааны дээд хэмжээ 5 жил /60 сар/ байх бөгөөд тухайн малчин, туслах малчны 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сайн дураар даатгуулсан хугацаанаас хойш 60 сарыг тооцно.

Малчин, туслах малчин даатгуулагч гэрээ байгуулах хүсэлт гаргасан тохиолдолд түүний өмнөх (2024) оны "Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тухайн оны тооллого"-ын жил бүрийн бүртгэл, эсхүл туслах малчны хөдөлмөрийн гэрээг үндэслэнэ.

Цахимаар гэрээ байгуулах даатгуулагчийн төрлийн "79004", "79014" кодтой даатгуулагч гэрээний дагуу эхний шимтгэлээ төлсөн ч хүсэлтийг нь хүлээн авсан байцаагч даатгуулагчийн цахимаар хавсаргасан "малчин" гэдгийг нотлох баримт бичгийг хянан шалгаснаар тухайн гэрээг хүлээн зөвшөөрч баталгаажуулна.

Даатгуулагчийн төрлийн "79004", "79014" кодтой малчин, туслах малчин даатгуулагч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс шимтгэл төлөхөд сард төлбөл

зохих шимтгэл 61380 төгрөг (тэтгэврийн даатгалын 5.75 хувь болох 45540 төгрөг, тэтгэмжийн даатгалын 1 хувь болох 7920 төгрөг, үйлдвэрлэлийн ослын даатгалын 1 хувь болох 7920)-ийг өөрөө төлсөн тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (792 000 төгрөг)-нээс тэтгэврийн даатгалын шимтгэлийн 5.75 хувиар тооцсон дүн болох 45540 төгрөгийг улсын төсвөөс төлүүлнэ.

Харин малчин, туслах малчин даатгуулагч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш орлогоос шимтгэл төлөх бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (792 000 төгрөг)-нээс тэтгэврийн даатгалын шимтгэлийн 5.75 хувиар тооцсон дүн буюу 45540 төгрөгийг улсын төсвөөс, үлдэх тэтгэврийн даатгалын шимтгэлийн зөрүү, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг даатгуулагч өөрөө бүрэн хариуцан төлнө.

1.4.Сайн дураар даатгуулагч гэрээний хугацаандаа 3 хүртэл насны хүүхдээ асарч буй эх, малчин, туслах малчин, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/ нөхцөлөөр гэрээг өөрчлөх хүсэлт гаргасан бол өмнөх гэрээгээр төлөхөөр тохирсон шимтгэлийн өргүй тохиолдолд дуусгавар болж, гэрээг шинээр байгуулна.

1.5.Даатгуулагч сайн дураар даатгуулсан хугацаанд Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээний дагуу ажилласан (даатгуулагчийн төрлийн "02001" код) тохиолдолд сайн дурын даатгалтай давхардуулан шимтгэл төлж болно.

1.6.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны "Журам, гэрээний заавар батлах тухай" А/200 дугаар тушаалаар баталсан "Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахад баримтлах журам"-ын 4.10-т "Даатгуулагч өмнө байгуулсан гэрээний хугацаа дууссаны дараагийн сард багтаан шимтгэл төлсөн тохиолдолд гэрээний хугацааг өмнөх гэрээний нөхцөлөөр үргэлжлүүлэн сунгасанд тооцно. Даатгуулагч өмнө нь байгуулсан гэрээний нөхцөлөө өөрчлөх тохиолдолд хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргаж холбогдох өөрчлөлтийг тусган гэрээний хугацааг сунгана" гэж заасан.

Иймд сайн дураар даатгуулагчийн 2024 онд байгуулсан гэрээний хугацаа 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тохиолдолд дээр дурдсан журамд заасны дагуу 2024 онд төлвөл зохих шимтгэлээ 2025 оны 01 дүгээр сард багтаан төлсөн даатгуулагчийн шимтгэлийг хугацаандаа төлснөөр тооцож, даатгуулагчийн гэрээг 2024 оны гэрээний нөхцөлөөр сунгана гэж хэрэгжүүлнэ.

Мөн журмын 4.12-т "Өмнө нь дуусгавар болсон гэрээний хугацаанд шимтгэлээ бүрэн төлөөгүй даатгуулагчийн тухайн төлөгдөөгүй хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлэхгүй" гэж заасан тул өмнө дуусгавар болсон буюу 2024 оноос өмнөх хугацаанд дуусгавар болсон гэрээний хугацаанд төлөгдөөгүй шимтгэлийг нөхөн төлүүлэхгүй.

1.7.Хүчин төгөлдөр байгаа гэрээний хугацаанд шимтгэлээ төлөөгүй тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3-т заасны дагуу тухайн төлөөгүй хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлж, алданги тооцно.

1.8.Даатгуулагч тухайн сард бүтэн ажиллаагүй, сарын дундуур ажилд орсон, цагаар ажилласан зэрэг шалтгаанаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин хөлснөөс шимтгэл төлсөн бол Засгийн газрын 2023 оны 470 дугаар тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам"-ын 3 дугаар зүйлд заасны дагуу нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал олгоход баримтлах шимтгэл төлж, ажилласан нийт хугацааг тодорхойлно.

2.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар:

2.1.Нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоох шимтгэл төлсөн хугацааны, хөдөлмөрийн хэвийн болон хэвийн бус нөхцөлд ажилласан байвал зохих хугацааны, эрэгтэй, эмэгтэй даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгох насны нөхцөлүүд өөрчлөгдөөгүй тул хэвээр мөрдөнө.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д заасан нөхцөлөөр 2025 онд нийгмийн даатгалын шимтгэлийг 22 жил ба түүнээс дээш хугацаанд төлсөн эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 нас хүрсэн даатгуулагч өөрөө хүсвэл түүнд өндөр насны тэтгэвэр тогтооно. Харин мөн хуулийн 5.1.2-т заасан нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох иргэн 2025 онд тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа (22 жил)-г хангаагүй буюу 20-21 жил 11 сар шимтгэл төлсөн тохиолдолд төрсөн ондоо харгалзах насанд хүрсэн бол өндөр насны бүрэн тэтгэвэр тогтоолгоно. Түүнчлэн тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-19 жил 11 сар төлсөн нөхцөлөөр өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгох даатгуулагч мөн төрсөн ондоо харгалзах тэтгэврийн насанд хүрсэн байна.

Түүнчлэн 2024 онд 20 ба түүнээс дээш жил шимтгэл төлж ажилласан, өндөр насны бүрэн тэтгэвэр тогтоолгох нөхцөлийг хангасан, түүнчлэн 10 ба түүнээс дээш жил шимтгэл төлж ажилласан өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгох нөхцөлийг хангасан төрсөн ондоо харгалзах өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн даатгуулагч тэтгэвэр тогтоолгох өргөдлөө 2025 онд гаргасан бол 2024 онд хангасан нөхцөлөөр нь тэтгэвэр тогтооно.

2.2.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.4-т заасны дагуу өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр шинээр тогтоолгох эхийн шимтгэл төлж, ажилласан хугацааг төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан хүүхдээ 6 нас хүртэл өсгөсөн хүүхэд бүрийн тоогоор нэмэгдүүлэх зохицуулалтыг доор дурдсанаар хэрэгжүүлнэ:

2.2.1.Өндөр насны тэтгэвэр тогтоолгох даатгуулагч эх тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа буюу 120 сар (10 жил) байх нөхцөлийг хангасан тохиолдолд түүний шимтгэл төлж ажилласан хугацааг хүүхэд бүрийн тоогоор нэмэгдүүлнэ;

2.2.2.Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох цэргийн алба хаагч эхийн алба хаасан хугацааг хүүхэд бүрийн тоогоор нэмэгдүүлэхдээ Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасны дагуу 1 жилийг 6 сараар тооцож цэргийн алба хаасан хугацааг нэмэгдүүлэн тооцно. Жишээ нь: Цэргийн алба хаагч эх нийтдээ 20 жил цэргийн алба хаасан, 5 жил шимтгэл төлж ажилласан, 3 хүүхэд төрүүлж өсгөсөн бол шимтгэл төлсөн 5 жилийг 2 жил 6 сараар, 3 хүүхдийн тоогоор нэмэгдүүлэх 4 жил 6 сарыг 2 жилээр тус тус тооцон, цэргийн алба хаасан хугацааг нэмэгдүүлнэ.

2.3.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу тэтгэвэр тогтоолгосноос хойш ажил хөдөлмөр эрхэлж албан журмаар даатгуулан тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол тэтгэврийн хэмжээг нь анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан сарын дундаж цалин хөлснөөс тооцон шимтгэл төлсөн сар тутамд 0.125 хувиар тооцон түүний хүсэлтэд үндэслэн нэмэгдүүлнэ.

2.4.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэгт заасны дагуу 2019-2023 онд тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчийн тэтгэврийг 5 жилийн дундаж цалин хөлснөөс өөрчлөн тогтоох бөгөөд бусад тэтгэвэр авагчийн тэтгэвэр тогтоолгосон цалинг өөр онуудын цалингаар өөрчлөхгүй.

Харин тэтгэврээ дундаж цалин хөлсгүйгээр тогтоолгосон тэтгэвэр авагч нь дараалсан 5 жилийн цалин хөлсөөр, эсхүл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын

сайдын 2023 оны "Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин батлах тухай" А/136 дугаар тушаалаар баталсан жишиг цалингаар тэтгэврээ өөрчлөн тогтоолгох хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд уг цалин хөлсийг Засгийн газрын 2025 оны "Итгэлцүүр тогтоох тухай" тогтоолоор баталсан итгэлцүүрээр өсгөн, цалин хөлсний сарын дээд хэмжээг баримтлан дундаж цалин хөлсөөр тооцон тэтгэврийг нь өөрчлөн тогтооно. Түүнчлэн тухайн тэтгэвэр авагч нь 2023.07.01-ний өдрөөс өмнө тэтгэврээ тогтоолгосон бол уг тэтгэврийг нь Засгийн газрын 2023 оны "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 239 дүгээр тогтоолын дагуу 10 хувиар, 2024 оны "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 120 дугаар тогтоолын дагуу 100.0 мянган төгрөгөөр, 2024 оны "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 221 дүгээр тогтоолын дагуу тэтгэврийн хэмжээг 6 хувиар тус тус нэмэгдүүлж, сарын тэтгэврийн хэмжээг шинэчлэн тогтооно.

2.5. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Цаашид "Хууль" гэх/-ийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчийн шинээр тогтоосон өндөр насны тэтгэврийн хэмжээ нь өмнө авч байсан хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн хэмжээнээс буурахаар бол өндөр насны тэтгэврийг хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн хэмжээгээр тогтоож олгоно гэж заасны дагуу өндөр насны тэтгэврийг хэмжээг доор дурдсанаар тогтооно:

2.5.1. Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-оос доошгүй жил төлсөн нөхцөлөөр хөдөлмөрийн чадвар алдсаны бүрэн тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчид өндөр насны бүрэн тэтгэврийн эрх үүсэхээр бол өндөр насны тэтгэврийн хэмжээг хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн хэмжээнээс нь бууруулахгүйгээр тогтоох;

2.5.2. Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу тэтгэврийн даатгалын шимтгэлийг 36 ба түүнээс дээш сар төлсөн нөхцөлөөр хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг бүрэн тогтоолгосон тэтгэвэр авагчид өндөр насны хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоох эрх үүсэхээр бол өмнөх хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн хэмжээгээр бус бодогдсон хэмжээгээр өндөр насны тэтгэврийг тогтоох;

2.5.3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох тохиолдолд энэ зөвлөмжийн 2.5.1, 2.5.2-т заасныг тус тус баримтлах;

2.5.4. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч Монгол Улстай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол тухайн хэлэлцээрээр уг асуудлыг зохицуулаагүй тул энэ зөвлөмжийн 2.5.1, 2.5.2, 2.5.3-т заасан зохицуулалтыг хэрэглэхгүй;

2.5.5. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 ба түүнээс дээш жил төлсөн нөхцөлөөр хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 5.1.5, 5.1.6, 5.1.7 дахь заалтын дагуу олон хүүхэдтэй эхийн, газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлийн, малчны, сонгодог, мэргэжлийн урлагийн, онцгой ажил мэргэжил (төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын алба)-ийн нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол энэ зөвлөмжийн 2.5.1-д заасан зохицуулалт хамаарна.

Харин хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч Цэргийн алба хаасны тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох бол Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг хамаарахгүй.

2.6.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт заасны дагуу даатгуулагчид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу хоёр тэтгэвэр авах эрх үүсэхээр бол шимтгэл төлсөн болон цэргийн алба хаасан хугацааг нэгтгэн тооцож нэг тэтгэвэр тогтооно.

10-аас доош жил иргэний байгууллагад шимтгэл төлж ажилласан цэргийн алба хаасны тэтгэвэр авагч уг хугацаагаар цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон хугацаагаа нэмэгдүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасны дагуу өөрчлөн тогтоох бөгөөд энэ тохиолдолд тухайн цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийг мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад заасан төрсөн ондоо харгалзах өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны нөхцөлийг хангасан байх шаардлага тавихгүй.

Харин Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн хуулиар уг хуульд өөрчлөлт орохоос өмнө цэргийн алба хаагчийн иргэний байгууллагад шимтгэл төлж ажилласан хугацаагаар цэргийн алба хаасан хугацааг нэмэгдүүлэх талаар зохицуулаагүй тул уг хууль батлагдахаас өмнө цэргийн алба хаагчийн иргэний байгууллагад шимтгэл төлж ажилласан хугацаагаар цэргийн алба хаасан хугацааг нэмэгдүүлэн тооцохгүй.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.26 дахь хэсэгт “Цэргийн жинхэнэ алба хаагч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол түүний цэргийн алба хаасан хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг ажил олгогчийн төлөх хувь хэмжээгээр дараах байдлаар тооцож, нийгмийн даатгалын зохих санд улсын төсвөөс тухай бүр төлнө” гэж заасан.

Иймд Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоолгох цэргийн алба хаагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг 2025 онд төлүүлэхдээ 2024 он хүртэл хугацаанд цэргийн алба хаагчийн авч байсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос Нийгмийн даатгалын тухай хууль /хуучин нэрээр/-ийн 15 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 137 дугаар тогтоолын 3 дахь хэсэгт заасны дагуу тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын шимтгэлийг төлүүлэх бөгөөд харин 2024 он ба түүнээс хойш хугацааны цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос доор дурдсанаар тэтгэврийн даатгалын шимтгэлийг тооцон, нөхөн төлүүлнэ. Үүнд:

1.Цэргийн алба хаагчийн цэргийн алба хаасан хугацааны зарим сарын эрүүл мэндийн даатгалын шимтгэл нь төлөгдөөгүй бол уг хугацааны шимтгэлийг холбогдох цэргийн анги, байгууллагын санхүүгийн архивын баримтад үндэслэн нөхөн төлүүлсний дараа уг хугацааг тэтгэвэр тогтоолгох шимтгэл төлж, ажилласан хугацаанд оруулан тооцно.

2.Цэргийн алба хаасан хугацааны цалин хөлсний баримт нь архивын сан хөмрөгт хадгалагдаагүй, олдохгүй, устсан, ажиллаж байсан цэргийн анги, байгууллага нь татан буугдсан бол уг хугацааны эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг холбогдох дээд шатны байгууллагаар нөхөн төлүүлсний дараа шимтгэл нөхөн төлсөн цалин хөлснөөс тооцсон шимтгэлийн дүнгээр улсын төсвөөс нэхэмжлэн төлүүлснээр шимтгэл төлж, ажилласан хугацаанд оруулан тооцно.

3.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар:

3.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох хугацаанд нийтээр тэмдэглэх баярын өдөр тохиосон бол уг өдрийг ажлын өдөртэй адилтган

тооцно”, мөн хуулийн 11.2 дахь хэсэгт “Ажилгүйдлийн тэтгэмж бодох хугацаанд нийтээр тэмдэглэх баярын өдөр тохиосон бол уг өдрийг ажлын өдөртэй адилтган тооцно” гэж тус тус заасны дагуу даатгуулагчийн тэтгэмж тооцон олгох өдрүүдэд тохиосон нийтээр тэмдэглэх баярын өдрийг ажлын өдөртэй адилтган тооцож тэтгэмж бодно. Жишээ нь: Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.2-т “Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1, 2, 3”-нд нийтээр амрахаар заасан. 2025 оны билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1, 2, 3- ны өдөр нь 2025 оны 03 дугаар сарын 01-02-ны өдөр тохиож байна. Эдгээрээс 03 дугаар сарын 01-ний өдөр бямба, 02-ны өдөр ням гаригт тохиож байгаа тул 03 дугаар сарын 01, 02-ны амралтын өдрийг ажлын өдрөөр тооцон жирэмсний болон амаржсаны, ажилгүйдлийн тэтгэмжийг бодож олгоно.

Мөн тэтгэмж авах өргөдлийг 2024 онд гаргасан даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хугацаа нь 2025 он дамжин нийтээр амрах баярын өдөр тохиосон бол тэтгэмж бодох ажлын өдөрт оруулан тооцож дээрх тэтгэмжүүдийг дахин тооцож зөрүүг нөхөн олгоно.

3.2.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Тэтгэмжийн хэмжээ тогтоох тухай” 08 дугаар тогтоолоор баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нөхцөлийг хангасан нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 2025 онд 2 000 000 төгрөг (хоёр сая)-өөр, тэтгэмж олгох нөхцөлийг хангасан, амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 3 500 000 төгрөг (гурван сая таван зуун мянган)-өөр тогтоосныг хэвээр баримтлан олгоно.

3.3.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасны дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч нас барсан бол нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг энэ зөвлөмжийн 3.2-т заасан тэтгэмжийн хэмжээгээр тооцон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгоно.

3.4.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад заасан төрсөн ондоо харгалзах өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрээгүй, хөдөлмөрийн чадвар алдсаны болон өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр ажлаас чөлөөлөгдсөн даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмж олгохгүй.

Түүнчлэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.5 дахь заалтад заасан хууль бусаар ажлаас чөлөөлөгдөж ажилгүйдлийн тэтгэмж авсан, Шүүхийн шийдвэрээр ажилдаа буцан орж, ажилгүй байсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэл нь төлөгдсөн даатгуулагчид өмнө олгосон ажилгүйдлийн тэтгэмжийг буцаан төлүүлэх талаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулиар тусгайлан зохицуулаагүй тул уг даатгуулагчид олгосон ажилгүйдлийн тэтгэмжийг буцаан төлүүлэхгүй.

3.5.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан даатгуулагч эх жирэмсний болон амаржсаны тэтгэмжтэй байх хугацаандаа хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрх үүссэн тохиолдолд уг тэтгэмжийг олгоно. Өөрөөр хэлбэл даатгуулагч эх жирэмсний болон амаржсаны тэтгэмж авч байх хугацаандаа хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг давхардуулан олгоно.

3.6.Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Малчын тухай хуулийг хэлэлцэн баталсан. Уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.9 дэх заалтад “хуульд заасан өндөр насны тэтгэвэр

тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх”, мөн хуулийн 4.3 дахь хэсэгт “Энэ хуулийн ... 4.2.9-д заасан арга хэмжээтэй холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулна” гэж заасан тул уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой журам батлагдсаны дараа холбогдох чиглэлийг хүргүүлнэ.

Иймд зөвлөмжийг сайтар судлан байцаагч, ажилтнууд, ажил олгогч, иргэд, даатгуулагчдыг мэдээллээр ханган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Та бүхэнд үүрэг болгож байна.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТ, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА



Ц.ГАНЦЭЦЭГ